

ҮР ХҮҮХДЭЭ ХҮМҮҮЖҮҮЛЭХЭД ХИЧЭЭХГҮЙ БАЙХ



ТУЛГУУР ОЙЛГОЛТ

Унхиа-Арчилгаа, арчаатай

Танхи-Ажил мэдэхгүй, залхуу хойрго

Бядтан-Хүч чадал суусан

Аламгай-Ажил хийхгүй зүгээр суух

Тэнгэр газарт ивээгдэх-ажил хөдөлмөрт хичээнгүй зүтгэгч

Чингис хааны зарлигийн товчоон

Унхиа⁸⁸ сайт айлын
Унага даага эрх аж
Унхиа муут айлын
Үр хүүхэд танхи⁸⁹ аж

Агтны нуруунд эмээл тохох бядтан⁹⁰ бүр
Аламгайг⁹¹ цээрлэн айл гэрээ өөд татагтун
Тэнгэр газарт хүч нэмэн ивээгдвээс⁹²
Төр улсаа засан төвхнүүлж чадмуй.

2022 оны эхний хагас жилд 12411 болж, өмнөх оны мөн үеэс 4944 (66.2%)-өөр өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 808 (6.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2402 (19.4%) нь эмэгтэйчүүд байна.



▸ **Хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох
суурь шалтгаан нь юу вэ?**

1.

2.

3.

Хайрын өлсгөлөн гэж юу вэ?

- Техник технологи хөгжсөн өнөө үед хүн бүр гар утас, компьютерийн урд суусаар гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг мартаж байна. Бид хайрын өлсгөлөнд удаан амьдарвал мөнгөний машин, ажлын робот болж хувирна
- Үндэсний статистикийн хорооноос гаргасан сүүлийн 4 жилийн судалгаагаар гэр бүл цуцлалт жил ирэх тусам нэмэгдэж, насны хувьд залуужиж байна гэсэн дүгнэлт гаргажээ. Насан туршид үргэлжлэх бат бөх харилцаанд хүрэхийг хичээж, гэрлэсэн олон хүмүүс гол төлөв сэтгэл хөдлөлд автан шийдвэр гаргадаг байна.
- Залуучуудын сонсож байгаа дуунуудын 70-80 хувь нь бүтэлгүй хайрын дуунууд байдаг. Үерхэл нөхөрлөл нь үнэгүйтэж салж нийлэх нь хэвийн үзэгдэл мэт болжээ. Манай улсад 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон ээж 40,500, өрх толгойлсон аав 8000 орчим байгаа нь эрх зүйн зохицуулалт шаардлагатай байхаас гадна, хүмүүс хайрын өлсгөлөнд байгааг харуулж байна.
- Хүн төрөлхтөн хайрын өлсгөлөнд орвол харгис, хатуу болно. Хайр дутагдвал гэр бүл сална, Хүнлэг чанар дутагдвал шударга бус нийгэм тогтоно.

Эцэг эхчүүдийн гаргадаг алдаа

- “Ухаан муутай тэнэг амьтан”, “Чамд хэдэн удаа хэлэх болж байна?”, “Үхсэндээ маяглаад байгаа мал вэ?”, “Шавар шавхайнд хутгалдсан мануухай”, “Яах гэж чамайг төрүүлэв ээ?”, “Адгийн новш” хэмээн байж боломгүй үгээр зэмлэдэг, загнадаг.
- Эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэхээс өмнө өөрийнхөө зан авир, үйлдлээ цэгцэлсэн байх шаардлагатай.
- Доромжлох, шалтгаангүйгээр загнах, олны өмнө эвгүй байдалд оруулах зэрэг үйлдэл гаргаж болохгүй
- Хүүхдээ тахин шүтэж, тэдний өмнө бөхөлзөж, алхам бүрт нь дагаж явдаг. Ийм хүүхэд эцэг, эхийн хараанаас холдоход л ямар нэг асуудал үүсгэдэг. Ихэнхдээ бүрэг, аймхай, бие даан шийдвэр гаргах чадваргүй болдог.
- Ах дүү хамаатан садны магтаалын бай болж “томчуулын хайр”-нд умбасан хүүхэд цэцэрлэг, сургуульд ормогц өөрийг нь хэн ч тоохгүй, анхаарал халамжгүй байгаа мэт санагддаг.

Хүүхдийг хэрхэн хайрлаж халамжлах вэ?



Хайр ишлэлүүд

Волтера

"Хайр бол байгалаас заяасан зураг бөгөөд төсөөлөн бодохоор хатгамал юм."

Хенри Уорд Бийчер

"Би хэрхэн хайрлахаа мэдэх хүртэл мөргөнө гэж хэзээ ч мэдэхгүй."

Эх Тереза

"Энэ дэлхийд талхнаас илүү хайр, талархал өлсгөлөн байдаг."